

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**ЭРДЭНЭБҮРЭН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН 2020 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Аудитын код: ХОА-2021/69/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Ховд хот 2021 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг: Tsetsegsuren.A@audit.gov.mn Аудитор: Б.Должинжав Утас: 70432545 цахим хаяг: Doljinjav.b@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

<i>АДБОУС</i>	<i>Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт</i>
<i>АОУС</i>	<i>Аудитын Олон Улсын Стандарт</i>
<i>УСНББОУС</i>	<i>Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт</i>
<i>ТТЗ</i>	<i>Төсвийн төвлөрүүлэн захирагч</i>
<i>ТШЗ</i>	<i>Төсвийн шууд захирагч</i>

Агуулга

1.Төрийн аудитын байгууллагын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	11
3. Аудитын тайлан.....	11
3.1. Ерөнхий зүйл.....	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	12
3.4. Материаллаг байдал	12
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	15
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	16
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.9. Аудитын илрүүлэлт.....	17
Залруулсан алдаа.....	17
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	17
Аудитын зөвлөмж.....	18
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	18
4. Менежментийн захидал.....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	19

1. ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

ЭРДЭНЭБҮРЭН СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
С.ОТГОНЧИМЭГ ТАНАА

2021.02.25 № 2/103
танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрдэнэбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Эрдэнэбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны тайлан, суралцагчийн сурлагын түвшин зэрэг санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Аудитын гол асуудал

Эрдэнэбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн биелүүлээгүй, төсвийн хөрөнгөөс актын төлбөр барагдуулж авлага үүсгэсэн, эд хөрөнгийн тооллогын үр дүнг данс бүртгэлд тусгаагүй, төсвийн хөрөнгийг үр ашигтай, арвилан хэмнэлттэй зарцуулаагүй /хоол хүнсний материал/, шилэн дансны хуулийн хэрэжилтийг хангаагүй, зарим зардлыг бүлэг хооронд зөвшөөрөлгүй гүйлгэн зарцуулсан зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох эрхзүйн актуудтай нийцэхгүй, аудитын "эрх ба үүрэг" "үнэн зөв" 021020261

байдал”, “тохиолдсон байх”, “иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	73,156,325.01	68,074,157.98
33	АВЛАГА	9,615,509.01	5,651,574.98
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	618,585.01	5,651,574.98
335	Бусад авлага	8,996,924.00	-
3351	Байгууллагаас авах авлага	8,996,924.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	63,540,816.00	62,422,583.00
351	Түүхий эд материал	-	466,600.00
35130	Эм боох материал	-	466,600.00
354	Хангамжийн материал	63,540,816.00	61,955,983.00
35410	Бичиг хэргийн материал	426,400.00	234,000.00
35420	Аж ахуйн материал	52,262,361.00	53,511,720.00
35460	Хүнсний материал	3,439,620.00	797,828.00
35470	Бусад хангамжийн материал	7,412,435.00	7,412,435.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,064,214,357.53	1,212,607,535.29
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,064,214,357.53	1,212,607,535.29
392	Биет хөрөнгө	1,005,589,357.53	1,154,060,660.27
39201	Барилга, байгууламж, орон сууц	981,669,329.00	1,100,208,740.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(59,478,493.32)	(89,217,739.98)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	160,431,356.00	209,464,012.67
39206	Хуримтлагдсан элэгдэл	(155,289,368.32)	(161,350,796.30)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	121,232,317.00	142,459,736.31
39208	Хуримтлагдсан элэгдэл	(76,683,740.83)	(81,401,250.43)
39217	Ном	33,707,958.00	33,897,958.00
393	Биет бус хөрөнгө	58,625,000.00	58,546,875.02
39301	Програм хангамж	625,000.00	625,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(78,124.98)
39303	Бусад биет бус хөрөнгө	58,000,000.00	58,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,137,370,682.54	1,280,681,693.27
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	529,200.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	529,200.00
413	Өглөг	-	529,200.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	529,200.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,137,370,682.54	1,280,152,493.27
51	Засгийн газрын хувь оролцоо	1,137,370,682.54	1,280,152,493.27
51100	Өмч төрийн	652,388,517.88	652,388,517.88
512	Хуримтлагдсан үр дүн	(371,105,541.34)	(228,323,730.61)
51210	Өмнөх үеийн үр дүн	(371,105,541.34)	(371,105,541.34)
51220	Тайлант үеийн үр дүн	-	142,781,810.73
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	856,087,706.00	856,087,706.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,137,370,682.54	1,280,681,693.27

2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	781,692,987.00	1,107,399,336.98
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	17,439,542.00	184,654,736.98
120	Нийтлэг татварын бус орлого	17,439,542.00	184,654,736.98
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	17,439,542.00	184,654,736.98

1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	400,000.00	400,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	17,039,542.00	184,254,736.98
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	764,253,445.00	922,744,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	627,263,700.00	809,922,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	627,263,700.00	809,922,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	22,550,245.00	1,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,644,145.00	1,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	906,100.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	114,439,500.00	111,822,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	114,439,500.00	111,822,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	807,366,594.17	964,617,526.25
21	УРСГАЛ ЗАРДАЛ	807,366,594.17	964,617,526.25
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	793,716,194.17	934,053,008.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	494,350,464.00	649,827,139.17
210101	Үндсэн цалин	383,132,794.00	426,119,084.77
210102	Нэмэгдэл	70,907,470.00	173,719,023.40
210104	Урамшуулал	40,310,200.00	49,989,031.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	62,266,900.00	81,457,055.76
210201	Тэтгэврийн даатгал	42,341,400.00	55,384,599.63
210202	Тэтгэмжийн даатгал	4,981,400.00	6,574,588.89
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,985,100.00	5,259,671.11
210204	Ажилгүйдлийн даатгал	996,300.00	1,293,857.23
210205	Эрүүл мэндийн даатгал	9,962,700.00	12,944,338.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	110,590,470.00	109,276,441.10
210301	Гэрэл, цахилгаан	3,656,170.00	6,760,341.10
210302	Түлш, халаалт	106,024,800.00	102,516,100.00
210303	Цэвэр, бохир ус	909,500.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	10,151,565.00	6,930,032.00
210401	Бичиг хэрэг	3,193,450.00	250,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,573,715.00	2,087,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	189,700.00	233,150.00
210404	Ном, хэвлэл	58,700.00	237,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	33,200.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	124,100.00	981,300.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	3,978,700.00	3,140,882.00
2105	Нормативт зардал	48,111,852.00	32,965,542.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	2,835,900.00
210502	Хоол, хүнс	47,794,776.00	28,691,524.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	317,076.00	1,438,118.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	530,160.00	404,350.00

210604	Урсгал засвар	530,160.00	404,350.00
2107	Томилолт, зочны зардал	113,400.00	44,400.00
210702	Дотоод албан томилолт	113,400.00	44,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	90,000.00	512,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	90,000.00	512,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	67,511,383.17	52,636,048.22
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,272,100.00	121,265.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	744,300.00	11,918,474.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	65,494,983.17	40,596,309.22
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,650,400.00	30,564,518.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,650,400.00	7,197,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	13,650,400.00	6,747,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	450,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	23,366,718.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	23,366,718.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(25,673,607.17)	142,781,810.73
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	10,940,000.00	
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(36,613,607.17)	142,781,810.73

2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	764,653,445.00	923,144,600.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	400,000.00	400,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	400,000.00	400,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	400,000.00	400,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	400,000.00	400,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	764,253,445.00	922,744,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	627,263,700.00	809,922,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	627,263,700.00	809,922,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	22,550,245.00	1,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,644,145.00	1,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	114,439,500.00	111,822,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	114,439,500.00	111,822,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	747,884,545.00	923,144,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	747,884,545.00	923,144,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	733,944,545.00	889,390,082.00

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	498,680,500.00	648,364,083.00
210101	Үндсэн цалин	380,915,200.00	425,813,841.87
210102	Нэмэгдэл	76,585,100.00	172,871,741.13
210104	Урамшуулал	41,180,200.00	49,678,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	62,266,900.00	87,529,517.00
210201	Тэтгэврийн даатгал	42,341,400.00	61,594,917.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,981,400.00	6,483,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,985,100.00	5,186,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	996,300.00	1,296,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,962,700.00	12,967,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	113,786,300.00	111,139,776.10
210301	Гэрэл, цахилгаан	6,342,000.00	6,775,341.10
210302	Түлш, халаалт	106,024,800.00	102,473,600.00
210303	Цэвэр, бохир ус	1,419,500.00	1,890,835.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,893,700.00	4,005,558.90
210401	Бичиг хэрэг	251,600.00	186,900.00
210402	Тээвэр, шатахуун	1,029,600.00	2,129,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	450,400.00	394,000.00
210404	Ном, хэвлэл	223,700.00	224,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	121,200.00	121,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	817,200.00	949,058.90
2105	Нормативт зардал	45,924,500.00	33,240,082.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	169,100.00	3,590,100.00
210502	Хоол, хүнс	44,582,700.00	27,977,282.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,172,700.00	1,672,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	974,800.00	653,200.00
210604	Урсгал засвар	974,800.00	653,200.00
2107	Томилолт, зочны зардал	163,100.00	163,100.00
210702	Дотоод албан томилолт	163,100.00	163,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	116,500.00	392,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	116,500.00	392,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,138,245.00	3,902,765.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,303,245.00	400,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,835,000.00	3,502,765.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,940,000.00	33,754,518.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,940,000.00	10,387,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	13,940,000.00	6,747,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	3,640,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	23,366,718.00

213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	23,366,718.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	16,768,900.00	-
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2019 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	652,388,517.88	856,087,706.00	(334,491,934.17)	1,173,984,289.71
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	652,388,517.88	856,087,706.00	(334,491,934.17)	1,173,984,289.71
Тайлант үеийн үр дүн	-	-	(36,613,607.17)	(36,613,607.17)
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	652,388,517.88	856,087,706.00	(371,105,541.34)	1,137,370,682.54
2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	652,388,517.88	856,087,706.00	(371,105,541.34)	1,137,370,682.54
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	652,388,517.88	856,087,706.00	(371,105,541.34)	1,137,370,682.54
Тайлант үеийн үр дүн	-	-	142,781,810.73	142,781,810.73
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	652,388,517.88	856,087,706.00	(228,323,730.61)	1,280,152,493.27

2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

ЭЗА	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	922,144,600.00	898,777,882.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	922,144,600.00	898,777,882.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	907,520,000.00	888,390,082.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	648,364,400.00	648,364,083.00
210101	Үндсэн цалин	425,815,600.00	425,813,841.87
210102	Нэмэгдэл	172,870,300.00	172,871,741.13
210104	Урамшуулал	49,678,500.00	49,678,500.00

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	87,529,200.00	87,529,517.00
210201	Тэтгэврийн даатгал	61,594,600.00	61,594,917.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,483,600.00	6,483,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,186,800.00	5,186,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,296,800.00	1,296,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,967,400.00	12,967,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	111,169,300.00	111,139,776.10
210301	Гэрэл, цахилгаан	6,976,200.00	6,775,341.10
210302	Түлш, халаалт	102,273,600.00	102,473,600.00
210303	Цэвэр, бохир ус	1,919,500.00	1,890,835.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,976,700.00	4,005,558.90
210401	Бичиг хэрэг	251,600.00	250,200.00
210402	Тээвэр, шатахуун	2,129,600.00	2,129,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	433,400.00	394,000.00
210404	Ном, хэвлэл	223,700.00	224,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	121,200.00	121,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	817,200.00	885,758.90
2105	Нормативт зардал	52,370,000.00	33,240,082.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,590,100.00	3,590,100.00
210502	Хоол, хүнс	47,107,200.00	27,977,282.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,672,700.00	1,672,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	653,200.00	653,200.00
210604	Урсгал засвар	653,200.00	653,200.00
2107	Томилолт, зочны зардал	163,100.00	163,100.00
210702	Дотоод албан томилолт	163,100.00	163,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	392,000.00	392,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	392,000.00	392,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,902,100.00	2,902,765.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	400,000.00	400,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,502,100.00	2,502,765.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,624,600.00	10,387,800.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,624,600.00	10,387,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,984,600.00	6,747,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,640,000.00	3,640,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	922,144,600.00	898,777,882.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	809,922,100.00	786,555,382.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	809,922,100.00	786,555,382.00

1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	111,822,500.00	111,822,500.00
132001	Орон нутгийн төсвөөс	111,822,500.00	111,822,500.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	400,000.00	400,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	400,000.00	400,000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	51.00	51.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	32.00	32.00
620003	Үйлчлэх ажилтан	18.00	18.00

2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,000,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,000,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,000,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00

3. АУДИТЫН ТАЙЛАН

3.1. Ерөнхий зүйл

Эрдэнэбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг захирал С.Отгончимэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд төсвийн төлөвлөлт, зарцуулалт, эд хөрөнгийн орлогын бүртгэл, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 18-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Должинжав хариуцаж хэрэгжүүлэв.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Эрдэнэбүрэн сумын ерөнхий боловсролын сургууль нь эрхэм зорилгоо “Суралцагч, багш, эцэг эхийн гурвалсан холбоог бэхжүүлэн, хүүхдэд ээлтэй, төлөвшилтэй суралцагч бий болгон, сургалтын таатай орчин бүрдүүлж, соёлтой үйлчилгээ түгээн ажиллахад оршино” гэж тодорхойлсон байна.

Үйл ажиллагааны чиглэл нь “Бага, дунд, ерөнхий боловсрол олгох” гэж заасан байна

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт
- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай
- Засгийн газрын 2020 оны 151 дүгээр тогтоол

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Төсвийн байгууллага нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль, журам стандартад нийцсэн ч санхүү, бүртгэлийн шинэчлэгдсэн хууль тогтоомж, заавар журамд нийцүүлэн шинэчлэлт, баяжуулалт хийгдээгүй байна.

Эрдэнэбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2016-2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 2020 оны 4 дүгээр сард хяналт шалгалт хэрэгжүүлж, тус сургуулийн захирал, нягтлан бодогч, нярав, багш, ажилчидтай холбогдсон 15509.2 мянган төгрөгийн төлбөрийн акт бичсэн байна.

Эрдэнэбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 818306.6 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 8183.1 мянган төгрөгөөр тооцсон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 964617.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 9646.2 мянган төгрөгөөр тооцсон болно.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Эрдэнэбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 143311.0 мянган төгрөгөөр өсчээ. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт нь үндсэн хөрөнгийн дансанд гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	73,156.3	68,074.2	(5,082.2)
33	Авлага	9,615.5	5,651.6	(3,963.9)
35	Бараа материал	63,540.8	62,422.6	(1,118.2)
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,064,214.4	1,212,607.5	148,393.2
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,137,370.7	1,280,681.7	143,311.0
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	529.2	529.2
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,137,370.7	1,280,152.5	142,781.8
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,137,370.7	1,280,681.7	143,311.0

Авлага дансны оны эхний үлдэгдэл дэх 9615.5 мянган төгрөгийн авлагын 8996.9 мянган төгрөг нь Боловсрол соёл урлагийн газраас хэрэгжүүлсэн сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийн санхүүжилтийг 2019 оны төгсгөлд авснаас шалтгаалан хэрэгжүүлж дуусгаагүй байсан учир авлагаар тооцоо үүсгэсэн, 618.6 мянган төгрөгийн авлага нь ажилчидтай холбоотой авлага нэрээр бүртгэгдсэн боловч эзэн холбогдогч нь тодорхойгүй байна.

Оны эцэс дэх авлагын үлдэгдэл 5651.6 мянган төгрөг нь дараах авлагаас бүрдсэн байна. Үүнд:

- Ажилтан, албан хаагчидтай холбогдсон актын төлбөрийг байгууллагаас барагдуулан, ажилчдаас авлагаар бүртгэсэн 4355.1 мянган төгрөг,
- Нийгмийн даатгалын шимтгэлийн илүү төлөлт 288.0 мянга, хувь хүний орлогын албан татварын илүү төлөлт 390.0 мянган төгрөг,
- Ажиллагсадтай холбогдсон 618.6 мянган төгрөгийн тодорхойгүй авлага бүртгэлтэй байгаа ба тухайн авлагыг нягталж, эзэн холбогдогчийг тодруулан барагдуулах зөвлөмж өглөө.

Бараа материалын данс оны эхэнд 63540.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба оны эцэст 62422.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан. Эргэлтийн бус эд хөрөнгийн тооллого хийсэн боловч тооллогын үр дүнг данс бүртгэлд тусгаж тайлагнаагүй байна.

Үндсэн хөрөнгө данс оны эхэнд 1355666.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан тайлант онд 188989.5 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, оны эцэст 1544655.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Хүснэгтээр харуулбал:

Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл	1,355,666.0
Нэмэгдсэн	188,989.5
Худалдан авсан	4,890.0
Хандиваар	31,160.2

Бусад	152,939.3
Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,544,655.4
Хуримтлагдсан элэгдлийн оны эхний үлдэгдэл	291,451.6
Элэгдлийн зардал тайлант хугацааны	40,596.3
Хуримтлагдсан элэгдлийн эцсийн үлдэгдэл	332,047.9
Үлдэгдэл өртөг	1,212,607.5

Тайлант хугацаанд 4890.0 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр худалдан авч, Боловсрол соёл, урлагийн газраас 40074.1 мянган төгрөгийн физикийн багаж, тоног төхөөрөмж, 23086.0 мянган төгрөгийн компьютер, ширээ сандал үнэ төлбөргүй хүлээн авч, Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар сургуулийн барилгын сантехник, дээврийн засварын ажлыг 118539.4 мянган төгрөгөөр Их дүүрэн ХХК, Хөх бугат ХХК-аар гүйцэтгүүлэн нягтлан бодох бүртгэлд тусгасан байна.

Тус сургуулийн захирлын 2020 оны 10 дугаар сарын 30 өдрийн А/51 тоот шийдвэрийн дагуу тооллогыг зохион байгуулсан боловч тооллогын үр дүнг үнэлж данс бүртгэлд тусгаагүй байна.

Биет бус хөрөнгөд 625.0 мянган төгрөгийн өртөгтэй, 78.1 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй санхүүгийн программ хангамж, 58000.0 мянган төгрөгийн үнэлгээтэй газар бүртгэлтэй байна.

Өр төлбөр данс оны эцэст 529.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаагаас 380.0 мянган төгрөг нь цалингаас суутгасан багш ажилчдын хуримтлалын тооцоо, 149.2 мянган төгрөг нь хувь хүмүүстэй холбоотой бараа үйлчилгээний зардлын өглөг бүртгэлтэй байна.

Засгийн газрын оруулсан капитал дансны үлдэгдэл оны эхэнд 652388.5 мянган төгрөг байсан ба тайлант онд өөрчлөлт ороогүй байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 325706.3 мянган төгрөгөөр буюу 1.4 дахин өссөн байна. Хүснэгтээр харуулав:

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	Өөрчлөлт
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	781,693.0	1,107,399.3	325,706.3
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	400.0	400.0	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	17,039.5	184,254.7	167,215.2
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	627,263.7	809,922.1	182,658.4
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	22,550.2	1,000.0	(21,550.2)
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	114,439.5	111,822.5	(2,617.0)

Өмнөх оны үзүүлэлтээс орлого материаллаг хэмжээгээр нэмэгдсэн шалтгаан нь тайлант онд үнэ төлбөргүй 184254.7 мянган төгрөгийн хөрөнгө хүлээн авсан, түүнчлэн тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт өмнөх оноос 182,658.4 мянган төгрөгөөр өссөн нь гол нөлөө үзүүлжээ.

Нийт зардал өмнөх оноос 157250.9 мянган төгрөгөөр буюу 1.2 дахин өссөн байна.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН		807,366.6	964,617.5	157,250.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	494,350.5	649,827.1	155,476.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	62,266.9	81,457.1	19,190.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	110,590.5	109,276.4	(1,314.0)
2104	Хангамж, бараа материалын зардал	10,151.6	6,930.0	(3,221.5)
2105	Нормативт зардал	48,111.9	32,965.5	(15,146.3)
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	530.2	404.4	(125.8)
2107	Томилолт, зочны зардал	113.4	44.4	(69.0)
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	90.0	512.0	422.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	67,511.4	52,636.0	(14,875.3)
213	Урсгал шилжүүлэг	13,650.4	30,564.5	16,914.1

Өмнөх оны үзүүлэлттэй харьцуулахад материаллаг өөрчлөлтөд цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл 174666.8 мянган төгрөгөөр өссөн нь гол нөлөө үзүүлсэн байна.

Дээрх зардал өссөн шалтгаан нь Засгийн газрын тогтоол, шийдвэрийн дагуу цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал нэмэгджээ.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүнд нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 728556.7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 728556.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 193587.9 мянган төгрөгөөр өсгөж 922144.6 мянган төгрөгөөр тайлант оны төсөв баталсан ба өмнөх оныхоос 180041.9 мянган төгрөгөөр өссөн байна. Үүнд цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал өмнөх оноос 170946.7 мянган төгрөгөөр өссөн нь гол нөлөө үзүүлжээ.

Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 922144.6 мянган төгрөгийн төсөв баталснаас 809922.1 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 111822.5 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 400.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 809922.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 111822.5 мянган төгрөгийн санхүүжилт бүрэн авч, туслах үйл ажиллагаанаас 400.0 мянган төгрөгийн орлого, нийт 922144.6 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж, урсгал үйл

ажиллагаанд 898777.9 мянган төгрөгийг зарцуулж, 23366.7 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 898777.5 мянган төгрөг буюу 97.5 хувьтай байгаа нь Ковид-19 вирусын цар тахлын нөхцөл байдлын улмаас улсын хэмжээнд ерөнхий боловсролын сургуулийн сургалтын үйл ажиллагааг тодорхой хугацаанд зогсоосноос хамаарч хоол хүнс, үдийн цайны зардал нийт 23366.7 мянган төгрөгөөр хэмнэгдсэнээс шалтгаалжээ.

Хөтөлбөр	Зориулалт	Арга хэмжээ	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт
71802	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	452,431.6	452,431.6	0.0
71802	80109	ТЗШ-ийн бга-уудын тогтмол зардал	111,822.5	111,822.5	0.0
71802	80801	Нөхөн олговор	3,640.0	3,640.0	0.0
71802	81801	Үдийн цай хөтөлбөр	10,984.6	6,747.8	-4,236.8
71802	81806	Дотуур байрны үйлчилгээ	168,423.6	149,293.7	-19,129.9
71802	81827	Бичиг үсгийн боловсролын хөтл	10,948.3	10,948.3	0.0
71802	81835	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	163,894.0	163,894.0	0.0
ДҮН			922,144.6	898,777.9	-23,366.7

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Зарим зардлыг бүлэг хооронд зөвшөөрөлгүй гүйлгэн зарцуулахаас гадна бүлэг дотор зохих бус зардлын эдийн засгийн ангиллаас гүйлгээ хийсэн зөрчил дутагдлууд байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар Боловсрол соёл, урлагийн газраас 1000.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, холбогдох арга хэмжээнд зарцуулжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 159 мэдээллээс 2 мэдээллийн хугацаа болоогүй, 18 мэдээллийг хугацаа хоцроож, 139 мэдээллийг хугацаанд нь оруулсан харагдаж байгаа боловч Шилэн дансны цахим хуудсанд оруулсан зарим мэдээллийн иж бүрэн, үнэн зөв, ойлгомжтой байдал нь хангалтгүй байна. Тухайлбал:

- ✓ Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын гүйлгээг мэдээлээгүй
- ✓ Байгууллагын батлагдсан төсөв, санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, бусад мэдээллийг бүрэн байршуулаагүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тус сургуулийн нярав Ш.Баттөмөрт “Хариуцлага тооцох” албан шаардлага хүргүүлснийг биелүүлсэн ч менежментийн захидлаар өгөгдсөн 3 зөвлөмжийг бүрэн биелүүлээгүй байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт

/мянган.төг

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт							
Албан шаардлага	1	60554.9	1	60554.9			100%
Зөвлөмж	3	44998.6			3	44998.6	
Нийт дүн	4	105553.5	1	25	4	105553.5	25

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 160059.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 123352.0 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, 358.4 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 13016.5 мянган төгрөгийн 6 алдаа, зөрчлийг таслан зогсоох албан шаардлага, 23332.7 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Үндсэн хөрөнгийн дансанд 2017, 2020 онуудад ашиглалтад орсон 20399.6 мянган төгрөгийн анхны өртөгтэй 3 нэр төрлийн хөрөнгөд тайлант хугацааны 1154.9 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг хуримтлуулж бүртгээгүй,
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар сургуулийн барилгын сантехник, дээврийн засварын ажлыг 118539.4 мянган төгрөгөөр гүйцэтгүүлсэн боловч нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд тусгаагүй,
- Бараа материалын тооцооны дансаар дамжуулахгүйгээр 3657.7 мянган төгрөгийн материалын үнийг шууд зардлаар бүртгэсэн

Нийт 123352.0 мянган төгрөгийн бүртгэлийн алдаа, зөрчилд залруулга хийв.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 358.4 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчилд төлбөрийн акт тогтоов. Үүнд:

Сургуулийн нийгмийн ажилтанд Г.Пүрэв-Очирт 2020 оны 11, 12 дугаар сард тэргүүлэх зэргийн нэмэгдлийг 25 хувиар буюу Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан хувь хэмжээнээс 5 хувиар илүү нийт 77.0 мянга, бичиг хэргийн ажилтан М.Энхзаяад 2020 оны 12 дугаар сард олговол зохих цалин хөлснөөс 281.4 мянган төгрөгийн илүү цалин хөлс тус тус тооцож олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-д “Төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Нягтлан бодогч нь дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах үүрэгтэй” Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтаар “Төрийн үйлчилгээний албан хаагчийг мэргэжлийнхээ дагуу тухайн албан тушаал эрхэлж байх хугацаанд мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтийг үндэслэн албан тушаалын сарын үндсэн цалингаас дор дурдсан хувиар бодож сар бүр олгоно” гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

Дараах алдаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв. Үүнд:

1. Эрдэнэбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн төрийн сангийн харилцах дансны цалингийн зардлаас Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд 4933.5 мянган төгрөгийн актын төлбөрийг төсвийн хөрөнгөөс барагдуулж, авлага үүсгэсэн
2. Ажилчидтай холбоотой 618.6 мянган төгрөгийн эзэн тодорхойгүй авлага он дамжин бүртгэгдсээр байгаа ба эзэн холбогдогчийг тодорхойлж барагдуулаагүй байна.
3. Эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгийн тооллого хийсэн боловч тооллогын үр дүнг тооцож данс бүртгэлд тусгаагүй байна,
4. Сургуулийн захирлын 2020.04.01-ны А/10 дугаар тушаалаар дотуур байрны хүнсний скаладанд байсан хадгалалтын горим, хугацаа, стандарт нэн чухал шаардлагатай болон шаардагдахгүй нийт 110 нэр төрлийн 7464.4 мянган төгрөгийн хүнсний материал устгалд оруулсан,
5. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн 3 зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6- д "Нягтлан бодогч нь эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах үүрэгтэй", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага бичих

Дараах алдаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв. Үүнд:

6. Шилэн дансны цахим хуудсанд оруулсан мэдээллийн үнэн зөв, бодитой, иж бүрэн байдал хангалтгүй, түүнчлэн таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын гүйлгээ, байгууллагын батлагдсан төсөв, санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, бусад мэдээллийг бүрэн байршуулж мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ.", ЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан журмын холбогдох заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага бичих

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 23332.7 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Тус сургууль 2020 онд Вивазоне ХХК-ийн нэгдсэн халаалтын системээс дулааны эрчим хүчээр хангагдсан ч тухайн онд байгуулсан гэрээ хэлцэл тодорхойгүй байна. Түүнчлэн батлагдсан төсвөөс хэтрүүлэн нэхэмжилсэн 67.0 сая төгрөгийн халаалтын тооцоог өр төлбөрөөр хүлээн зөвшөөрч, тооцоо нийлж баримтжуулсан байна.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Төсвийн төлөвлөлт, зарцуулалттай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Төсвийн төлөвлөлтийг оновчтой төлөвлөөгүй, түүнчлэн зарим зардлыг бүлэг хооронд зөвшөөрөлгүй гүйлгэн зарцуулахаас гадна бүлэг дотроо зохих бус зардлын эдийн засгийн ангиллаас гүйлгээ хийсэн байна.

1.2. Эрсдэл: Төсвийн тухай хууль зөрчигдөх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх эрсдэлтэй

1.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй, гэсэн заалттай нийцүүлж төсвийг бодитой төлөвлөж, батлагдсан төсвийн хүрээнд зохих зардлын эдийн засгийн ангиллаас зарцуулж, үнэн зөв тайлагнах

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

2. Эд хөрөнгийн орлогын бүртгэлтэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Боловсрол соёл урлагийн газраас 2019 онд хэрэгжүүлсэн 21604.8 мянган төгрөгийн 2 тэтгэлэгт хөтөлбөрийн санхүүжилтээр бий болсон эд хөрөнгийг данс бүртгэлд бүрэн тусгаагүй

2.2. Эрсдэл: Эд хөрөнгийн дутагдах, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх эрсдэлтэй

2.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-д “Санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв бүртгэж, тайлагнах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.2-д “Нягтлан бодох бүртгэлд бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг заавал бүртгэнэ” гэсэн заалтуудтай нийцүүлж эд хөрөнгийг данс бүртгэлд бүрэн тусгах

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

3. Нягтлан бодох бүртгэл, тайлагналын талаар

3.1. Илрүүлэлт: Эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгийн ангилал, түүнчлэн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн зардлыг буруу ангилан бүртгэсэн байна.

3.2. Эрсдэл: Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан буруу илэрхийлэгдэх

3.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-д “Санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв бүртгэж, тайлагнах” гэсэн заалттай нийцүүлж санхүүгийн бүртгэл тайлагналыг үнэн зөв илэрхийлэх

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧИЙН ЖАГСААЛТ

Огноо:	Аудитын нэр:	Эрдэнэбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2020			ХОА-2021/69/СТА-ТШЗ

Шалгагдсан
байгууллагын нэр:

**Эрдэнэбүрэн сумын ерөнхий боловсролын
сургууль**

Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5	
1	Сургуулийн нийгмийн ажилтанд Г.Пүрэв-Очирт 2020 оны 11, 12 дугаар сард тэргүүлэх зэргийн нэмэгдлийг 25 хувиар буюу Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан хувь хэмжээнээс 5 хувиар илүү нийт 77.0 мянга, бичиг хэргийн ажилтан М.Энхзаяад 2020 оны 12 дугаар сард олговол зохих цалин хөлснөөс 281.4 мянган төгрөгийн илүү цалин хөлс тус тус тооцож олгосон байна.	358.4	Төлбөрийн акт	Дарга, нягтлан бодогч	С.Отгончимэг, Н.Пүрэвдэлгэр
2	Эрдэнэбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн төрийн сангийн харилцах дансны цалингийн зардлаас Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд 4933.5 мянган төгрөгийн актын төлбөрийг төсвийн хөрөнгөөс барагдуулж, авлага үүсгэсэн	4933.5	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	С.Отгончимэг, Н.Пүрэвдэлгэр
3	Ажилчидтай холбоотой 618.6 мянган төгрөгийн эзэн тодорхойгүй авлага он дамжин бүртгэгдсээр байгаа ба эзэн холбогдогчийг тодорхойлж барагдуулаагүй байна.	618.6	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	С.Отгончимэг, Н.Пүрэвдэлгэр
4	Эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгийн тооллого хийсэн боловч тооллогын үр дүнг тооцож данс бүртгэлд тусгаагүй байна	-	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	С.Отгончимэг, Н.Пүрэвдэлгэр
5	Сургуулийн захирлын 2020.04.01-ны А/10 дугаар тушаалаар дотуур байрны хүнсний скаладанд байсан хадгалалтын горим, хугацаа, стандарт нэн чухал шаардлагатай болон шаардагдахгүй нийт 110 нэр төрлийн 7464.4 мянган төгрөгийн хүнсний материал устгалд оруулсан	7464.4	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	С.Отгончимэг, Н.Пүрэвдэлгэр
6	Шилэн дансны цахим хуудсанд оруулсан мэдээллийн үнэн зөв, бодитой, иж бүрэн байдал хангалтгүй, түүнчлэн таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын гүйлгээ, байгууллагын батлагдсан төсөв, санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, бусад мэдээллийг бүрэн байршуулж мэдээлээгүй байна.	-	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	С.Отгончимэг, Н.Пүрэвдэлгэр
7	Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн 3 зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй	-	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	С.Отгончимэг, Н.Пүрэвдэлгэр
8	Төсвийн төлөвлөлтийг оновчтой төлөвлөөгүй, түүнчлэн зарим зардлыг бүлэг хооронд зөвшөөрөлгүй гүйлгэн зарцуулахаас гадна бүлэг дотроо зохих бус зардлын эдийн засгийн ангиллаас гүйлгээ хийсэн байна.	-	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	С.Отгончимэг, Н.Пүрэвдэлгэр
9	Боловсрол соёл урлагийн газраас 2019 онд хэрэгжүүлсэн 21604.8 мянган төгрөгийн 2 тэтгэлэгт хөтөлбөрийн санхүүжилтээр бий болсон эд хөрөнгийг данс бүртгэлд бүрэн тусгаагүй.	-	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	С.Отгончимэг, Н.Пүрэвдэлгэр
10	Эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгийн ангилал, түүнчлэн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн зардлыг буруу ангилан бүртгэсэн байна.	23332.7	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	С.Отгончимэг, Н.Пүрэвдэлгэр
11	Үндсэн хөрөнгийн дансанд 2017, 2020 онуудад ашиглалтанд орсон 20399.6 мянган төгрөгийн анхны өртөгтэй 3 нэр төрлийн хөрөнгөд тайлант	1154.9	Залруулсан	Дарга, нягтлан бодогч	С.Отгончимэг, Н.Пүрэвдэлгэр

	хугацааны 1154.9 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг хуримтлуулж бүртгээгүй,				
12	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар сургуулийн барилгын сантехник, дээврийн засварын ажлыг 118539.4 мянган төгрөгөөр гүйцэтгүүлсэн боловч нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд тусгаагүй,	118539.4	Залруулсан	Дарга, нягтлан бодогч	С.Отгончимэг, Н.Пүрэвдэлгэр
13	Бараа материалын тооцооны дансаар дамжуулахгүйгээр 3657.7 мянган төгрөгийн материалын үнийг шууд зардлаар бүртгэсэн	3657.7	Залруулсан	Дарга, нягтлан бодогч	С.Отгончимэг, Н.Пүрэвдэлгэр
ДҮН		160059.6			

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР